



## “МОНГОЛ БАЗАЛЪТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2021 оны 04-р сарын 26-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн Хувьцаа Эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурал  
хүчин төгөлдөр болсныг батлах тухай

Компаний тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, 2021 оны 4 дүгээр сарын 26-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МОНГОЛ БАЗАЛЪТ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 56,417,000 ширхэг хувьцаа эзэмшдэг 2383 хувьцаа эзэмшигчдээс 14 хувьцаа эзэмшигч онлайнаар холбогдсон нь 39,996,847 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрхтэй хувьцааны 70,9% болж Хувьцаа Эзэмшигчдийн Хурал хуралдуулах ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг зөвшөөрч баталсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН

ДАРГА



Ц. БАЙГАЛМАА



## “МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 26 өдөр

№ 02

Улаанбаатар хот

Компанийн Хувьцаа Эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудал  
тус бүрийн саналын дүнг нэгтгэн батлах тухай

Компаний тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, 2021 оны 4 дүгээр сарын 26-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах, эсэх: Санал хураалтын дүнгээр 100% зөвшөөрсөн тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.
2. “МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж, батлах эсэх: Санал хураалтын дүнгээр 100% зөвшөөрсөн тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат болон хараат бус гишүүдийг сонгох, эсэх: Санал хураалтын дүнгээр 100% зөвшөөрсөн тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.
4. “МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулалын хэмжээг батлах, эсэх: Санал хураалтын дүнгээр 100% зөвшөөрсөн тул шийдвэр хүчинтэйд тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН

ДАРГА



Ц. БАЙГАЛМАА



## **“Монгол Базальт” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл**

2021-04-26

№01

Улаанбаатар хот

“Монгол Базальт” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04-р сарын 26-ны өдөр Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хороо Үйлдвэрийн тойруу-132-т байрлах Компанийн өөрийн байрнаас улс оронд үүсээд байгаа нөхцөл байдал, МУЗГ-ын хорио цээрийн дэглэм тогтоосон тогтоолыг үндэслэн цахимаар шууд дамжуулан хийж байна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 14:13 цагт эхлэв.

“Монгол Базальт” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолыг тооллогын комиссын дарга А. Энхгэрэл танилцуудлаа.

Тооллогын комиссын дарга А. Энхгэрэл, гишүүд Д.Сайнбаатар, Ц.Байгалмаа..

### **Танилцуулсан нь:**

“Монгол Базальт” ХК-ийн Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл : 2021 оны ХЭХ-г албан ёсоор нээснийг мэдэгдэе. Улаанбаатар хотод 2021 оны 04 сарын 26 16:13 мин болсон байна. Цахим бүртгэлээр бүртгүүлсэн нийт 14 хувьцаа эзэмшигч буюу 39,496,847 ш саналын эрхтэй хувьцаа буюу нийт 70,9 хувийн ирцтэй байна.

4 Сарын 8-ны өдрийн байдлаар 2383ш хувьцаа эзэмшигч буюу 56,417,000ш нээлттэй хувьцаа арилжаалагдсан байна.Хурлын материалд хавсаргасан

Түүхэн замнал

Хүний нөөц

Бидний амжилт

Бидний бүтээгдэхүүн

2020 оны үр дүнгийн талаар танилцуулав.

### **Өнөөдрийн хэлэлцэх асуудал:**

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлан ТУЗ-н гаргасан дүгнэлт, хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах.
2. Монгол Базальт ХК-ийн дүрэмд орох нэмэлт өөрчлөлтийг танилцуулах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах
4. ТУЗ-н гишүүний цалин, урамшуулалын хэмжээ, тогтоолын төсөл

**Танилцуулсан нь:**

1. “Монгол Базальт” ХК-ийн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

2020 оны бизнес төлөвлөгөөний гол зорилго бол сүүлийн 4 жилд үргэлжилж буй технолгийн дамжлагууд дээрх шинэчлэл, бүтээн байгуулалтын капитал хөрөнгө оруулалтын нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний нэр төрөл тоо хэмжээг төрөлжүүлэх, дотоодын борлуулалтын сувгуудын тогтолцоог сайжруулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээг авч ажиллахад чиглэсэн. Энэ онд 6,7 тэрбумын борлуулалттай ажиллах төлөвлөгөөтэй эхэлсэн боловч Covid-19 цар тахалтай холбоотойгоор 3,1 тэрбум төгрөгийн борлуулалт хийж үнэт цаасны танилцуулга дээрх төлөвлөгөөний биелэлт 47% өмнөх оноос цэвэр ашиг 2 хувиар буурсан хэдий ч компани алдагдалтай ажиллаагүйн сацуу онцгой нөхцөл байдлын эрсдэлийн төлөвлөгөөтэй амжилттай ажиллаж борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 3 хувиар бууруулж, үйл ажиллагааны зардалыг 29 хувиар танаж жилийн эцэсээр ашигтай ажилласан байна. “Монгол Базальт ХК” сүүлийн 4 жилд үйлдвэрлэлийн технологийн шинэчлэлийн хүрээнд 10 тэрбум төгрөгийн капитал хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд үүний 48 хувийг татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтаар үлдсэн 52 хувийг өөрийн санхүүгийн эх үүсвэрээр санхүүжүүлж ажилласан.

### **III үйлдвэрлэсэн нь:**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.11 заалт, “Монгол Базальт” хувьцаат компанийн 2021 оны 04-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн үндэслэн ТОГТООХ нь.

1. “Монгол Базальт” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.

### **2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн жинхэнэ болон хараат бус гишүүдийг сонгох**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД-ийг та бүхэнд танилцуулъя. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, компанийн дүрмийн 6.1.5.9 дахь заалтуудын тус тус үндэслэн “Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулахаар хуулийн хугацаанд шалгаруулалт зарласан бөгөөд шинээр нэр дэвшигч бүртгэгдээгүй тул 2019-2020 онд тус компанийн ТУЗ-ийн бүрэлдхүүнд багтан хамтран ажиллаж байсан дараах нэр бүхий гишүүдийг дахин нэр дэвшүүлж байна.

### **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД:**

1. Шаравсамбуу ЭНХТӨР-Эрх зүйч, банкны удирдлага

2. Чансаа ЗОРИГТБААТАР- хуульч, эдийн засагч
3. Түвшинтөр ЦЭНД-АЮУШ-бизнесийн удирдлага, компанийн засаглалын эксперт, Эдийн засагч
4. Пүрэвсүх НЯМДОРЖ- Бизнесийн удирдлага

#### **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД.**

1. Лхагважав АРИУНБОЛД-Цахиурын исэлд суурилагдсан эрдэсийн хайлах болон дулаанаар боловсруулах технологийн үйлдвэрийн инженер, эдийн засагч
2. Галбадрах ГАНЗОРИГ-Цэргийн командлагч, улс төр судлаач
3. Ариунболд ЭНХГЭРЭЛ-Үйлдвэр үйл ажиллагааны менежмент, санхүү менежмент
4. Пүрэвбанзрагч САЙНБИЛЭГ-Технологийн инженер, санхүүч
5. Бадарч ШАРАВСАМБУУ-Нягтлан бодогч, гавьяат эдийн засагч
6. Хан Гю Бунг /Han Kyu Bong/-Бизнес удирдлагын мастер

#### **Шийдвэрлэсэн нь:**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.9 дэх заалт, компанийн 2021 оны 04 сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

НЭГ. “Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

1. Лхагважав овогтой Ариунболд
2. Галбадрах овогтой Ганзориг
3. Ариунболд овогтой Энхгэрэл
4. Пүрэвбанзрагч овогтой Сайнбилэг
5. Бадарч овогтой Шаравсамбуу
6. Хан Гю Бунг /Han Kyu Bong/

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

1. Шаравсамбуу овогтой Энхтөр
2. Чансаа овогтой Зоригтбаатар
3. П. Нямдорж нарыг тус тус сонгосугай.

ХОЁР. Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм, дотоод журмуудад заасан үүргээ хариуцлагатай гүйцэтгэж, компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүдэд үүрэг болгосугай.

### **3. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох**

“Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ

ТУЗ-ийн гишүүдийн цалин Хэмжээ /төгрөг/

Тогтмол цалин Үндсэн 1,000,000 ₮

ТУЗ-ийн даргын нэмэгдэл 200,000 ₮

Хорооны даргын нэмэгдэл 100,000 ₮

Оролцоонд үндэслэсэн нэмэгдэл цалин: Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд биечлэн оролцсон тоогоор 100,000 ₮

Хурлууд: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Жилдээ 1 удаа

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал Жилдээ 4 удаа

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны хурал Жилдээ 4 удаа

ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны хурал Жилдээ 2 удаа

ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны хурал Жилдээ 1 удаа байхаар тооцоолон санал хүргүүлж байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.15 заалт, компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2020 оны 04-р сарын 26-ны өдрийн шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Базальт” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг сар бүрт нь тооцон олгохыг Ерөнхий нягтлан бодогч-д үүрэг болгосугай.

#### **ХЭЛЭЛЦСЭН нь:**

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ А.ЭНХГЭРЭЛ:** За одоо та бүхний цахимаар ирүүлсэн асуулгад хариулья. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зохион байгуулах комисс болон тооллогын комиссын бүрэлдэхүүн цахимаар ирүүлсэн асуултуудыг уншиж танилцуулна уу?

**Ерөнхий менежер Д.Сайнбаатар:** Дараах асуулт ирлээ.

#### **Асуулт:**

1. Экспортын төлөвлөгөөний талаар танилцуулаарай-

#### **Хариулт:**

Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл: - Өнгөрсөн 3,4 жилд экспортын төлөвлөгөө гарган ажилласан бөгөөд үүний хүрээнд Солонгос улсад цөөн тооны бүтээгдэхүүн гаргасан. 2020 оны хувьд цар тахалын нөлөөгөөр экспортод гаргах боломж хараахан гарсангүй мөн сүүлийн 2 жилд манай дотоод зах зээлд ипортын дулаалгын материал нөөц бага хомсдол үүссэн тул манай дотоод зах 25 хувиар нэмэгдсэн учраас бид дотоод зах зээлд дулаалгын материалын хомсдол,

үнийн хөөргөдөл үүсэхээс сэргийлж дотоод зах зээлээ хангах нь чухал гэж дүгнэсэн байгаа. Дотоод зах зээл эрэлт буурж тогтворжисон үед экспортод гаргах төлөвлөгөөтэй байна. Анхны төлөвлөж байсан хугацаа хойшилж байна.

**Асуулт:**

- 2. Үнэ өндөр байгаа шалтгаанар борлуулалт бага байгаа талаар тайлбар өгөөч**

**Хариулт:**

Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл: 1м3 бүтээгдэхүүнийг ипортын бүтээгдэхүүнтэй харьцуулахад манай бүтээгдэхүүн 8-15%-иар хямд байгаа. Манай 60кг/м3 нягттай хөвөнг зах зээлд борлуулж байгаа шилэн хөвөнтэй 1м2-ын үнээр харьцуулан ойлголтын зөрүү үүсээд байдаг. Манай чулуун хөвөн зах зээл дээр байгаа чулуун хөвөнгийн дундаж үнээр борлуулагддаг. Зарим төрлийн шинээр гарсан базалит flex бол зах зээл дээр хамгийн хямдаар борлуулж байгаа чулуун хөвөн байгаа.

- 3. Асуулт: Шинэ залуу гэр бүлийг дэмжих бүтээгдэхүүний хөнгөлөлт байдаг уу?**

**Хариулт:** Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл: Хаан, Хас, Төрийн банкны ногоон зээлээр авах боломжтой мөн хороо дүүргүүд дээр явагдаж байгаа тосол хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой. Мөн манай хаягаар өөрийн хүсэлт өргөдөлөө явуулж болно тухайн хүсэлтийг манай менежерүүд тухайн онд нийгмийн хариуцалгын хүрээнд хийх боломжтой гэж үзвэл шийдвэрлэдэг байгаа.

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ А.ЭНХГЭРЭЛ- “Монгол Базальт” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд цахимаар ирүүлсэн асуулталд хариулж дууссан ба цахим санал хураалтын цаг эхэлсэн тул түр завсарлаж байна. ХЭХ-ын тооллогын комисс цахимаар ирүүлсэн саналын хуудсыг тоолж дүнгээ гарган тогтоолоо танилцуулна уу.**

**“Монгол Базальт” ХК-ийн ХЭХ-ын тооллогын комиссын дарга Ц. БАЙГАЛМАА:**

**За та бүхэнд ХЭХ-ийн тооллогын комиссын тогтоолыг танилцуулья.**

**ХҮРЛЫН ДАРГА**



**А. ЭНХГЭРЭЛ**



## “МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04-р сарын 26-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд  
Төлөөлөн удирдах зөвлөлийн өгсөн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9-д заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.11-д заалт, 2021 оны 04 сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



А.ЭНХГЭРЭЛ



## МОНГОЛ БАЗАЛЫТ ХК-ИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

“Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдөж, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 2020 оны бизнес төлөвлөгөөний гол зорилго нь сүүлийн 4 жилийн хугацаанд үргэлжилж буй үндсэн технологийн дамжлагууд дээрх шинэчилэлт бүтээн байгуулалтын капитал хөрөнгө оруулалтын ажлуудыг дүгнэн капиталжуулах, үүний сацуу үйлдвэрлэлийн бүтээмжийг ахиулах, бүтээгдэхүүний тоо хэмжээг төрөлжүүлэх, дотоодын борлуулалтын сувгуудын тогтолцоог сайжруулах, чиглэсэн удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллахад чиглэсэн билээ.

2020 онд дэлхий даяар тархсан Ковид-19 цар тахалд автаж, манай улсын эдийн засаг, ААН-үүдийн үйл ажиллагаа улс даяар доголдсон хүнд жилтэй нүүр тулсан билээ. “Монгол Базальт” компани нь хамгийн багадаа 6.7 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллах төлөвлөгөөтэй оныг эхлүүлсэн хэдий ч сүүлийн хагас жилийн хөл хорионы нөхцөл байдалтай холбогдуулан алдагдсан боломжын орлого үүсч 3.1 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж үнэт цаасны танилцуулга дээрх төлөвлөгөөний биелэлт 47%, өмнөх оноос цэвэр ашиг 2%-иар буурсан хэдий ч, компанийн хүрээнд алдагталтай ажиллаагүйн сацуу, онцгой нөхцөл байдлын үеийн эрсдлийн төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүлснээр ББӨ-г 3%-иар бууруулан жилийн эцсээр ашигтай ажилласан гүйцэтгэлтэй байна.

“Монгол Базальт” ХК нь сүүлийн 4 жилийн хугацаанд үйлдвэрлэлийн технологийн шинэчилэлт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 10 орчим тэрбум төгрөгийн капитал хөрөнгө оруулалт хийж, үүний 48%-г татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтаараа, үлдсэн 52%-г компани өөрийн эх үүсвэрээр санүүжүүлж ажилласан байна. Үйлдвэрлэлийн гарц, чанар, бүтээгдэхүүний нэр төрөл олширч, цаашид зах зээлийн тэлэлт хийхэд бүрэн бэлэн болсон байна.

Иймд Монгол Базальт ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2020 онд төлөвлөсөн зорилгоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



## **“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 04-р сарын 26-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

“Монгол базальт” ХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1-д заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.1-д заалт, 2021 оны 04 сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, компанийн дүрмийн эхийг хавсралтаар баталсугай.

2. “Монгол базальт” ХК-ийн дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /А.Энхгэрэл/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



А.ЭНХГЭРЭЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 04 сарын 26-ны өдрийн 2 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт



**“Монгол базальт” ХК-ний дүрэмд  
зруулах нэмэлт, өөрчлөлт**

| № | Одоогийн заалт                                                                                                                                                            | Нэмэлт, өөрчлөлт орсон байдал                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | 6.1.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна.                                                                                              | 6.1.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зайнаас /мэдээллийн технологи, доргооом хангамж ашиглан хурлын бүх үйл ажиллагааг цахимаар/ болон хосолсон /танхим болон цахимаар/ хэлбэрээр зохион байгуулж болно.                                                                                                                                                                                                                                                              |
| 2 |                                                                                                                                                                           | 6.1.2 <sup>1</sup> Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахдаа мэдээллийн технологийн зохих туршлага бүхий компанитай гэрээ байгуулж хамтран ажиллана. Энэ тохиолдолд хуралд оролцогчийг системд бүртгэх, түүний саналыг авах, ирцийн мэдээ болон авсан саналын дүнг өөрчлөх боломжгүй үнэн зөв илэрхийлэх боломжтой програмыг бүтээх үүргийг мэдээллийн технологийн компани хариуцна. Түүнчлэн мэдээллийн технологийн компани нь энэхүү үүргээ баталгаажуулсан баталгаа бүхий албан бичгийг компанид хүлээлгэн өгнө. |
| 3 |                                                                                                                                                                           | 6.1.15 Зайны болон хосолсон хурлын материал, хурлын үйл явцын бүтэн дүрс бичлэг, санал хураалтын баримт зэргийг засварлах, өөрчлөх боломжгүй хэлбэрт шилжүүлэн компанийн цахим архивын баримт болгож хадгална.                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| 4 |                                                                                                                                                                           | 6.1.16 Хурлыг хуралдуулах боломжгүй техникийн нөхцөл үүссэн тохиолдолд хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг ТУЗ товлон.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| 5 | 6.2.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 гишүүн нь ердийн, 3 нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 1 жил байна. | 6.2.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 гишүүн нь ердийн, 3 нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2 жил байна. ТУЗ-ийн гишүүдийг хэдэн ч удаа улируулан сонгож болно.                                                                                                                                                                                                                                                                                                          |
| 6 | 6.2.6.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн                                                         | 6.2.6.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах хэлбэр сонгох, хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх                                                                                                                                                                                                                                                                                        |

|   |                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
|---|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   | өдөр болон хувьцаа<br>эзэмшигчдийн хурлыг<br>хуралдуулахтай холбогдох<br>бусад асуудлыг<br>шийдвэрлэх                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| 7 |                                                                                                                                                                                                                                                                  | 6.2.7 <sup>1</sup> ТУЗ-ийн хурлыг видео конференцийн хэлбэрээр эсхүл ТУЗ-ийн гишүүдийн албан ёсны цахим хаягаар мэдээлэл солилцох хэлбэрээр саналыг нь авах замаар эчнээ хэлбэрээр явуулж болно. Энэ тохиолдолд ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга нь гишүүдийг тухайн хуралд оролцох, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар санал өгөх, санал хураалтад оролцох боломжоор хангаж ажиллана. |
| 8 | 6.2.8 ТУЗ-ийн хурлыг<br>ТУЗ-ийн дарга, түүний<br>гишүүд, компанийн<br>гүйцэтгэх захирал<br>/гүйцэтгэх удирдлага/<br>болон энэ дүрэмд заасан<br>бусад этгээдийн<br>санаачлага, шаардлагаар<br>хуралдуулна. ТУЗ эчнээ<br>санал хураалтаар шийдвэр<br>гаргаж болно. | 6.2.8 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал /гүйцэтгэх удирдлага/ болон энэ дүрэмд заасан бусад этгээдийн санаачлага, шаардлагаар хуралдуулна.                                                                                                                                                                                                        |

“Монгол базальт” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021  
оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хурлын  
№ 2 тоот тогтоолоор батлав.



## “МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 “Монгол Базальт” компани нь Монгол Улсад бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани /цаашид “компани” гэж нэрлэх/ болно.
- 1.2 Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль болон энэхүү дүрмээр компанийн үйл ажиллагааг зохицуулна.
- 1.3 Компанийн өнөөсөн албан ёсны нэр:
  - Монголоор: “Монгол Базальт” хувьцаат компани (цаашид “Монгол Базальт” ХК гэж товчилно.)
  - Англиар: “Mongol Basalt” Joint Stock Company гэнэ.
- 1.4 Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энх тайвны өргөн чөлөө, Фламинго Тауэрын 7 давхар
- 1.5 Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд ХК гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.
- 1.6 Компани нь ТУЗ-ийн шийдвэрээр салбар, төлөөлөгчийн газар, хараат болон охин компани байгуулж болно.
- 1.7 Компани өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас тэмдэгтэй байна.
- 1.8 Компани өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байх бөгөөд түүний загварыг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэж нэрлэх/ баталж, хууль тогтоомжийн дагуу бүртгүүлсэн байна.
- 1.9 Компанийн бэлгэдэл, барааны тэмдгийг хэрэглэх эрхийг зөвхөн “Монгол Базальт” ХК эдэлнэ.
- 1.10 Компани нь удирдлага, компанийн засаглал сайтай, ил тод, нээлттэй, нийгмийн болон хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хариуцлага хүлээсэн компани байна.

### Хоёр. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

- 2.1 Компани нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:
  - Барилгын материалын үйлдвэрлэл;
  - Гадаад дотоод худалдаа;
  - Төсөл хөтөлбөр;
  - Сургалт судалгаа;



### **Гурав. Хувь нийлүүлсэн хөрөнгө**

- 3.1 Компани нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 56,417,000 ширхэг зарласан энгийн хувьцаатай байна.
- 3.2 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө 5 641 700 000 /таван тэрбум зургаан зуун дөчин нэгэн сая долоон зуун мянган/ төгрөг байх ба гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүн буюу хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн нийт хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ.
- 3.3 Компанийн давуу эрхийн хувьцаа гаргасан тохиолдолд хувьцаа эзэмшигч нь “Компанийн тухай” хуульд заасан нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцоно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх, тэдний хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл зэргийг давуу эрхийн хувьцаа гаргах тухай асуудлыг шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрт заасан байна.
- 3.4 Шинээр давуу эрхийн хувьцаа гаргах болон энгийн хувьцаа нэмж гаргасан тохиолдолд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон хувьцааны тоо нэмэгдэнэ.
- 3.5 Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлж, хорогдуулж болно.
  - 3.5.1 Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх;
  - 3.5.2 Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөлгүйгээр хувьцааг хуваах эсхүл нэгтгэх;
  - 3.5.3 Хувьцаа нэмж гаргах болон худалдан авсан халаасны хувьцааг хүчингүй болгох;
- 3.6 Компани гүйлгээнд гаргасан өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авч болно.

### **Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, хариуцлага**

- 4.1 Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааг эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.
- 4.2 Хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:
  - 4.2.1 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах эрх бүхий этгээдээс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;
  - 4.2.2 ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсаны дараа эзэмшиж буй хувьцаанд ногдол ашиг авах;
  - 4.2.3 Компанийг татан буулгах үед Компанийн тухай хулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;

- 4.2.4 Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй. Энэ давуу эрхийг эдлэх боломжийг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ хангана.
- 4.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар доорх асуудлаар шийдвэр гаргахдаа эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр компанийн дүрэмд заасан үндсэлэл, журмаар өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхтэй. Үүнд:
- 4.3.1 Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх;
  - 4.3.2 Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх;
  - 4.3.3 Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
- 4.4 Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигчид нь жил бүрийн 3 дугаар сарын 1-ээс өмнө ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д гишүүн нэр дэвшүүлэх эрхтэй.
- 4.5 Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 болон 96 дугаар зүйлийн 96.1-д заасан бичиг баримтуудтай энгийн хувьцаа эзэмшигч бүр танилцах эрхтэй.
- 4.6 Хувьцаа эзэмшигч нь дараах үүрэг хүлээнэ:
- 4.6.1 Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны таваас дээш хувийг дангаараа болон бусадтай хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын 3 хоногийн дотор компанид бичгээр мэдэгдэх үүрэгтэй;
  - 4.6.2 Нийт гаргасан хувьцааны 1/3 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу тендер санал зарлах;
  - 4.6.3 Компани хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хариуцлага хүлээхгүй;
  - 4.6.4 Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ;
  - 4.6.5 Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувьцаа эзэмшигчдийн хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс зааглагдсан болно;

**Тав. Компанийн үнэт цаасыг гаргах  
худалдах, эргүүлэн авах**

- 5.1 Компани нь энгийн хувьцаанаас гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах опцион зэрэг үнэт цаас гаргаж болно.
- 5.2 Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн үед Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.
- 5.3 Зарласан хувьцаанаас нэмж гаргах асуудлыг ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэнэ.
- 5.4 Нэмж гаргасан хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэхийн тулд хувьцаа худалдаж авах эрхийн бичиг гаргана. Энэ эрхийн бичгээр тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн дагуу хэрэгжүүлнэ.
- 5.5 Компани өрийн бичиг гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. ТУЗ-ийн шийдвэрт гаргах өрийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, нөхцөл, эргэж төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.
- 5.6 Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно.
- Опцион худалдаж авч болох энгийн хувьцаа нь гүйлгээнд байгаа нийт хувьцааны 25 хувиас бага бол опцион гаргах тухай шийдвэрийг ТУЗ, түүнээс их бол хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана. Шийдвэрт гаргах опционы тоо, нэгж опцион эзэмшигчдийн худалдан авч болох хувьцааны тоо, хувьцаа худалдаж авах үнэ, опционы хүчинтэй байх хугацаа, опционыг санал болгох үнэ зэргийг заасан байна.
- 5.7 Хувьцаанд хөрвөх үнэт цаасаар хөрвөх хувьцааны тоо, нийт гаргасан опционоор худалдах хувьцааны тоо, гүйлгээнд гаргасан хувьцааны тоо зэргийн нийлбэр нь нийт зарлагдсан хувьцааны тооноос илүү байж болохгүй.
- 5.8 Компаниас шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг мөнгө, үнэт цаас, эд хөрөнгийн болон эрхийн хэлбэрээр хийж болно.
- 5.9 Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдаж авах шийдвэрийг энгийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдаж авахаас бусад тохиолдолд ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэртээ худалдаж авах үнэт цаасны төрөл, тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.

**Зургаа. Компанийн удирдлага**

- 6.1. **Хувьцаа эзэмшигчийн хурал:**
- 6.1.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
- 6.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зайнаас /мэдээллийн технологи, программ хангамж ашиглан хурлын бүх үйл ажиллагааг цахимаар/ болон хосолсон /танхим болон цахимаар/ хэлбэрээр зохион байгуулж болно.

- 6.1.2<sup>1</sup> Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахдаа мэдээллийн технологийн зохих туршлага бүхий компанитай гэрээ байгуулж хамтран ажиллана. Энэ тохиолдолд хуралд оролцогчийг системд бүртгэх, түүний саналыг авах, ирцийн мэдээ болон авсан саналын дүнг өөрчлөх боломжгүй үнэн зөв илэрхийлэх боломжтой программыг бүтээх үүргийг мэдээллийн технологийн компани хариуцна. Түүнчлэн мэдээллийн технологийн компани нь энэхүү үүргээ баталгаажуулсан баталгаа бүхий албан бичгийг компанид хүлээлгэн өгнө.
- 6.1.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас дөрвөн сарын дотор буюу жил бүрийн 5 дугаар сарын 1-ний дотор ТУЗ зарлан хуралдуулна.
- 6.1.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.
- 6.1.5. Дор дурдагдсан асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:
- 6.1.5.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу шинэчилсэн найруулгыг батлах;
  - 6.1.5.2. Нийлэх, нэгдэх, хуваах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;
  - 6.1.5.3. Компанийн өрийг хувьцаагаар солих;
  - 6.1.5.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
  - 6.1.5.5. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
  - 6.1.5.6. Зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх;
  - 6.1.5.7. Хувьцаа нэмж гаргах, хувьцааны тоог тогтоох;
  - 6.1.5.8. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
  - 6.1.5.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;
  - 6.1.5.10. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэх эсэх;
  - 6.1.5.11. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт болон Хянан шалгах зөвлөлийн тайланг хэлэлцэж батлах;
  - 6.1.5.12. Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг хийх тухай шийдвэрийг ТУЗ санал нэгтэй гаргаж чадаагүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхиор шийдвэрлэх;

- 6.1.5.13. Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
- 6.1.5.14. Компанийн тухай хуульд заасны дагуу компани өөрийн гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авахыг зөвшөөрөх;
- 6.1.5.15. Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- 6.1.5.16. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
- 6.1.5.17. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуульд заасан бусад;
- 6.1.5.18. ТУЗ-өөс Хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд.
- 6.1.6. Нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход саналын эрхийн тоог тогтоохдоо тухайн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох гишүүдийн тоогоор үржүүлэх замаар кумулятив<sup>1</sup> аргаар тооцно.
- 6.1.7. Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн биеэр буюу Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно.
- 6.1.8. Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүчинтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй хэвээр байна.
- 6.1.9. Саналын эрхийн 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор Хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно.
- 6.1.10. Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ.
- 6.1.11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн дүрмийн 6.1.5.1-6.1.5.8 заалт дахь асуудлыг хэлэлцэж буй бол хувьцаа эзэмшигчдийн саналын лийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 6.1.12. Хуралд биечлэн оролцох хувьцаа эзэмшигч, мөн хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдөр хүртэл бүртгэнэ. Бүртгэлийг тооллогын комиссын дарга эсхүл түүний томилсон этгээд гүйцэтгэнэ.
- 6.1.13. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхдээ хамаарах асуудлыг эцнээ санал хураалтаар шийдвэрлэж болно. Энэ заалт нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хамаарахгүй. Компанийн нийт гаргасан хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид

<sup>1</sup> СЗХ-ны "Санал хураах кумулятив иргэн хэрэглэх журам"-ыг хэрэглэнэ.

хүсвэл эцнээ санал хураалтын дүнг нэгтгэн гаргах тооллогын комиссын үйл ажиллагаанд ажиглагчаар оролцох эрхтэй.

6.1.14. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тогтоолыг Компанийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан журмын дагуу хөтөлж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдсон дарга баталгаажуулан гарын үсэг зурна.

6.1.15. Зайны болон хосолсон хурлын материал, хурлын үйл явцын бүтэн дүрс бичлэг, санал хураалтын баримт зэргийг засварлах, өөрчлөх боломжгүй хэлбэрт шилжүүлэн компанийн цахим архивын баримт болгож хадгална.

6.1.16. Хурлыг хуралдуулах боломжгүй техникийн нөхцөл үүссэн тохиолдолд хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг ТУЗ товлони.

## 6.2. Төлөөлөн удирдах зөвлөл:

6.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

6.2.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 гишүүн нь ердийн, 3 гишүүн нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 2 жил байна.

6.2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

6.2.4. ТУЗ-ийн гишүүн мэргэшил, ёс зүйн өндөр шаардлага хангасан компанийн эрх ашгийг тэргүүн ээлжинд эрхэмлэдэг этгээд байвал зохино.

6.2.5. ТУЗ нь гишүүдийн олонхийн саналаар ТУЗ-ийн даргыг сонгоно.

6.2.6. ТУЗ нь Компанийн тухай хууль болон энэ дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.2.6.1. Энэ дүрэмд заасан үнэт цаас гаргах шийдвэр гаргах;

6.2.6.2. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, компанийн бүтэц, зохион байгуулалт, энэ дүрэмд заагаагүй үйл ажиллагааны чиглэлийг тогтоох буюу компанийн урт, дунд хугацааны стратеги болон жил бүрийн бизнес төлөвлөгөө, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах;

6.2.6.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

6.2.6.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах хэлбэр сонгох, хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн өлөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;

6.2.6.5. ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн жилийн санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж цаашид авах арга хэмжээний талаар санал оруулах;

- 6.2.6.6. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- 6.2.6.7. Компанийн Гүйцэтгэх захирал болон Гүйцэтгэх удирдлагын багийг өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох, компанийн Гүйцэтгэх захирал болон компанийн үйл ажиллагаанд тавих байнгын хяналтыг хэрэгжүүлэх;
- 6.2.6.8. Компанийн Гүйцэтгэх захирал болон Гүйцэтгэх удирдлагын багтай байгуулах гэрээний нөхцөл, олгох шагнал, урамшуулал, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн хүргэх түвшин, өртөг зардал, ашиг зэрэг асуудлуудыг тусгах;
- 6.2.6.9. ТУЗ-ийн дарга Гүйцэтгэх захирлыг гадаадад томилолтоор ажиллах удирдамж төсвийг батална. ТУЗ-ийн Хурлаар томилолтын үр дүнг хэлэлцэнэ.
- 6.2.6.10. Компанийн аудиторыг сонгож, түүнтэй хийх гэрээний нөхцөлийг тогтоох;
- 6.2.6.11. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;
- 6.2.6.12. Ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журмыг тодорхойлох;
- 6.2.6.13. Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
- 6.2.6.14. Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 6.2.6.15. Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 6.2.6.16. Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 6.2.6.17. Эрх бүхий албан тушаалтнаас компанид учруулсан хохирлыг нэхэмжлэл гаргах;
- 6.2.6.18. Гадаад, дотоодын байгууллага, банктai хамтран ажиллах, хувь нийлүүлсэн хөрөнгө оруулах, компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр компанийн хөрөнгө барьцаалах, баталгаа гаргах;
- 6.2.6.19. Компанийн ажилтан нарын нийгмийн асуудалтай холбоотой асуудлыг шийдвэрлэх;
- 6.2.6.20. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал;
- 6.2.6.21. Компанийн дотоод аудитын газрын дарга, ажилтнуудыг томилох, цалин, хөлсний хэмжээг тогтоох, ажиллах журмыг батлах;
- 6.2.6.22. Орон нутагт салбар зөвлөд, мэргэжлийн болон бизнесийн зөвлөд зэргийг байгуулан, үйл ажиллагааных нь журмыг тогтоож, төсвийг батлах;

#### 6.2.6.23. Хуульд заасан бусад.

- 6.2.7. ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулна. Шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдаан хийж болно. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна. Тогтоолд дарга гарын үсэг зурна. ТУЗ албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байж болно.
- 6.2.7<sup>1</sup> ТУЗ-ийн хурлыг видео кенференцийн хэлбэрээр эсхүл ТУЗ-ийн гишүүдийн албан ёсны цахим хаягаар мэдээлэл солилцох хэлбэрээр саналыг нь авах замаар эцнээ хэлбэрээр явуулж болно. Энэ тохиолдолд ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга нь гишүүдийг тухайн хуралд оролцох, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар санал өгөх, санал хураалтад оролцох боломжоор хангаж ажиллана.
- 6.2.8. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал /гүйцэтгэх удирдлага/ болон энэ дүрэмд заасан бусад этгээдийн санаачилга, шаардлагаар хуралдуулна.
- 6.2.9. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-өөс томилно. ТУЗ-ийн хурлын зохион байгуулалтыг нарийн бичгийн дарга хариуцаж протокол хөтөлж хадгална. Хурлын тухай зар, материалыг хурал хуралдахаас 3-аас доошгүй хоногийн өмнө ТУЗ-ийн гишүүдэд хүргэнэ.
- 6.2.10. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдана. ТУЗ-ийн дарга оролцох боломжгүй тохиолдолд түүний итгэмжлэгдсэн ТУЗ-ийн гишүүн хурлыг удирдана.
- 6.2.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийнх нь дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.
- 6.2.12. Тухайн шийдвэрлэж байгаа асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүн санал өгөх эрхгүй байвал шийдвэрийг саналын эрхтэй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гишүүн нь эсрэг саналтай байвал түүнийгээ протоколд тэмдэглүүлэх эрхтэй.
- 6.2.13. ТУЗ-ийн гишүүн 6 сараас дээш хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон эсхүл нас барсан тохиолдолд ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудал хэлэлцэх Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэлх хугацаанд ТУЗ-өөс тухайн гишүүнийг орлох этгээдийг томилно.
- 6.2.14. ТУЗ-ийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос 2 дахин бага болсон тохиолдолд ТУЗ-ийн гишүүд 3 сарын дотор ТУЗ-ийн гишүүдийг сонгохоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.
- 6.2.15. ТУЗ-ийн гишүүд нь зохих хэмжээний урамшуулал авах бөгөөд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно.
- 6.2.16. ТУЗ-ийн өөрийн дэргэд үйл ажиллагаагаа үр өгөөжтэй байлгахын тулд байнгын болон түр хороог байгуулж болно. Харин аудитийн, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороог заавал байгуулах бөгөөд хууль, компанийн засаглал, ил тод байдлын болон хөрөнгө оруулалт-

санхүү, эрсдэлийн дэд хороодтой байж болно. Тэдгээрийн чиг үүргийг журмаар тогтооно.

6.2.17. Хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

6.2.18. ТУЗ-ийн гишүүдийн хууль бус үйл ажиллагаанаас компанид хохирол учруулсан бол ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

#### ***Аудитын хороо:***

6.3 ТУЗ-ийн аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн байх бөгөөд санхүү, бүртгэл эрсдлийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн байна.

6.4 ТУЗ-ийн аудитын хороо нь дараах чиг үүрэгтэй байна.

6.4.1 Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

6.4.2 Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;

6.4.3 Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилж, уалин урамшууллын талаарх гүйцэтгэх удирдлагын саналыг хянах, ТУЗ-д танилцуулах;

6.4.4 Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах, хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитын байгууллагад чиглэл өгөх /чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитын байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ/

6.4.5 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих;

6.4.6 Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг

#### ***Нэр дэвшүүлэх хороо***

6.5 ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо нь дараах чиг үүрэгтэй:

6.5.1 ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

6.5.2 ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигч нь ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, хараат бус гишүүний хувьд энэ дүрмийн 6.6-д заасан шалгуурыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;

6.5.3 ТУЗ-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх /саналын хуудсанд шууд нэрийг нь оруулах/

6.5.4 ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

6.5.5 Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцлийг тодорхойлох;

6.5.6 ТУЗ-ийн гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтны ажил үүргийн гүйцэтгэлд гүйцэтгэх захирлын өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

6.5.7 Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг

6.6 ТУЗ-д нэр дэвшсэн аливаа этгээийн нэрийг саналын хуудсанд оруулах эсэх тухай асуудлыг хэлэлцэхдээ тухайн этгээд нь дараах нөхцөл байдлыг хянах үүрэгтэй;

6.6.1 Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан ТУЗ-ийн гишүүнд тавигдах ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлагын талаарх шаардлагыг хангаж байгаа эсэх;

6.6.2 Жил бүрийн хувыцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хуралдуулаагүй, эсхүл зохих журмын дагуу хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсон ТУЗ-д ажиллаж байгаа эсэх;

6.6.3 Өмнө нь компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан этгээдийн нэрийг дахин дэвшүүлж байгаа бол ТУЗ-ийн гишүүний хувьд үүргээ зохих ёсоор хэрэгжүүлсэн эсэх;

6.6.4 Компанийн засаглалын чиглэлээр сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан эсэх;

6.7 Дор дурьдсан этгээд ТУЗ-ийн гишүүн байхыг хориглоно:

6.7.1 Эрх зүйн чадамжгүй;

6.7.2 Урьд нь эдийн засаг, аж ахуйн нэгжийн эсрэг гэмт хэрэгт шийтгэгдсэн бөгөөд ялтай байх хугацаа нь дуусаагүй байгаа;

6.7.3 Өмнө нь дампуурсан хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалд ажиллаж байсан;

6.7.4 Компанийн тухай хуулийн 81.5.7-д заасан хугацаа өнгөрөөгүй байгаа;

6.7.5 Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас 2 болон түүнээс дээш удаа захиргааны хариуцлага хүлээж байсан;

#### **Цалин урамшууллын хороо**

6.8 Цалин урамшууллын хороо нь дараах чиг үүрэгтэй:

6.8.1 Эрх бүхий албан тушаалтан цалин урамшууллын талаарх баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

6.8.2 Эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах;

6.8.3 Компанийн цалин урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;

6.8.4 Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг

#### **6.9 Гүйцэтгэх удирдлага:**

- 6.9.1 Компанийн гүйцэтгэх захирал нь энэ дүрэм болон контрактаар ажиллах гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компаний өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.
- 6.9.2 ТУЗ компанийн гүйцэтгэх захирлыг томилж, түүнтэй контракт байгуулна. Компанийн гүйцэтгэх удирдлагыг гэрээний үндсэн дээр багаар хэрэгжүүлж болно.
- 6.9.3 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болох бөгөөд ТУЗ-ийн дарга, өөр компани, аж ахуйн нэгжийн гүйцэтгэх захирлаар давхар ажиллахыг хориглоно. Гүйцэтгэх захирал нь компанийн нэрийн өмнөөс гэрээ хэлцэл хийх зэрэг Монгол улсын Компанийн тухай хууль болон энэ дүрэмд заасан эрх эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:
- 6.9.3.1 Компанийн хэтийн төлөв, бодлого, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал боловсруулж ТУЗ-ийн хуралд оруулж батлуулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 6.9.3.2 Хараат /охин/ компани, салбар, төлөөлөгчийн газрын захирлуудыг томилох саналыг ТУЗ-д оруулан батлуулах, тэдэнтэй компанийг төлөөлөн хөдөлмөрийн гэрээ болон контракт гэрээг байгуулах;
- 6.9.3.3 Компанийн хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулна.
- 6.9.3.4 Компанийн хөдөлмөрийн дотоод журам болон бусад журмыг батлах;
- 6.9.3.5 ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал, шийдвэр гаргах;
- 6.9.3.6 Компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хүмүүстэй харилцаж, ТУЗ-өөс олгосон эрхийн хүрээнд гэрээ хэлцэл, хэлэлцээр байгуулах;
- 6.9.3.7 Энэ дүрэм, ТУЗ-өөс олгосон эрхийн хүрээнд компанийг төлөөлөх итгэмжлэл олгох;
- 6.9.3.8 Монгол Улсын хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагын шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан тогтоол, ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;
- 6.9.3.9 Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцах;
- 6.9.3.10 Хувьцаа эзэмшигчдийг ТУЗ-ийн хурлын шийдвэр, компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангана.
- 6.9.3.11 ТУЗ-ийн хуралд компанийн хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны талаар ажлаа хариуцан тайлагнана.
- 6.9.3.12 Гүйцэтгэх захирлын албан тушаалаас чөлөөлсөн буюу тэрээр чөлөөлөгдөх хүсэлт тавьсан тохиолдолд шинээр гүйцэтгэх

захирлыг сонгох хүртэл ТУЗ-өөс томилсон этгээд гүйцэтгэх захирлын үүргийг түр гүйцэтгэнэ.

6.9.4 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн даргад гаргаж болно.

6.9.5 Гүйцэтгэх захирал нь томилогдсоноосоо хойш 15 хоногийн дотор гарын үсгийн хэвийг бүртгэх байгууллагад тэмдэглүүлнэ.

#### **Долоо. Компанийн эрх бүхий албан тушаалтны хүлээх хариуцлага**

- 7.1 ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд, ерөнхий нягтлан бодогч, хараат болон охин компаниудын захирлуудыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.
- 7.2 Компанийн эрх бүхий албан тушаалтан нь энэхүү дүрэм, ТУЗ-өөс гаргасан тогтоол, дүрэм, журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана. ТУЗ-ийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууцад хамрагдах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдагч этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно.
- 7.3 Компанийн эрх бүхий албан тушаалтанд хуриуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг түүнтэй байгуулсан хөдөлмөрийн болон контракт гэрээ, компанийн дотоод дүрэм, журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ. Хариуцлагыг Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасны дагуу хүлээлгэнэ.

#### **Найм. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан, нэгдөл ашгийн хуваарилалт**

- 8.1. Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлан:
  - 8.1.1. Компани Монгол Улсын хуулиар тогтоосон журам болон олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөн сар, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргаж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржээс тогтоосон нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад зохих хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.
  - 8.1.2. Компанийн санхүүгийн жил тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна. Компанийн санхүүгийн тайлан, түүний үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал хариуцна.
  - 8.1.3. Компанийн гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлага нь компанийн хувьцаа эзэмшигч нараас дүрмийн санд оруулсан мөнгөн хөрөнгийг ТУЗ-өөс баталсан төсвийн хүрээнд үр ашигтай, хэмнэлттэй, зориулалт ёсоор компанийн үндсэн зорилго, зорилтын дагуу зарцуулна.
- 8.2. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан:
  - 8.2.1. Компани дор дурдсан бүртгэлийг заавал хөтөлнө:

8.2.1.1. Үнэт цаас, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг компани хариуцна. Үнэт цаасны бүртгэлийг Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй гэрээ байгуулан хөтлүүлнэ.

8.2.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл болон хурлын шийдвэрийн бүртгэл, хурлын тэмдэглэл, хурлын шийдвэрийн бүртгэлд хурал хийсэн байр, он, сар, өдөр, хурлын дарга, протокол хөтөлсөн этгээдийн овог, нэр, гишүүдийн ирц, хэлэлцсэн асуудал, шийдвэр, саналын хуудас, тооллогын комиссын шийдвэр;

8.2.1.3. ТУЗ-ийн хурлын тэмдэглэл, хурлын шийдвэрийн бүртгэл, энэ бүртгэлд хурал хийсэн байр, он, сар, өдөр, хурлын дарга, протокол хөтөлсөн этгээдийн овог, нэр, гишүүдийн ирц, хэлэлцсэн асуудал, шийдвэр;

8.2.1.4. Аудитын хорооны хурлын тэмдэглэл, шийдвэрийн бүртгэл, энэ бүртгэлд хурал хийсэн байр, он, сар, өдөр, хурлын дарга, протокол хөтөлсөн этгээдийн овог, нэр, гишүүдийн ирц, хэлэлцсэн асуудал, шийдвэр;

8.2.1.5. Компанийн дүрэм, журам, бусад этгээдтэй байгуулсан бүх гэрээ хэлцэл, хэлэлцээр;

8.2.1.6. Ирсэн, явсан албан бичиг түүний бүртгэл;

8.2.1.7. Хууль болон эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэр, дүрэм, журмаар тогтоосон заавал хөтлөх бүртгэл;

8.3. Санхүүгийн тайланд дараах үндсэн бүрдэл хэсгүүд заавал орсон байна. Үүнд:

8.3.1. баланс;

8.3.2. орлого, үр дүнгийн тайлан;

8.3.3. мөнгөн гүйлгээний тайлан;

8.3.4. өмчийн өөрчлөлтийн тайлан;

8.3.5. тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчил бүхий хэлцэлийн жагсаалт, төрөл, үнийн дүн, хэлцэлд оролцогч талуудын мэдээлэл;

8.3.6. нэмэлт, тайлбар, тодруулга;

8.3.7. бусад.

8.4. Санхүүгийн тайланг гаргахад хэрэглэсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэл тооцсон аргууд, орлогын зохицуулалт, хараат болон охин компаниудад оруулсан санхүүгийн хөрөнгө, оролцооны хувь хэмжээ, ногдол ашгийн бодлого, хуримталсан ашиг, үнэ ханшны хэлбэлзэлийг тайланд хэрхэн тусгасан тухай болон хууль тогтоомжид заасан шаардлагатай бусад тайлбар, тодруулгыг заавал хийсэн байна.

8.5. Санхүүгийн жилийн тайланг хөндлөнгийн аудитаар хянуулаж, үр дүнг хувьцаа эзэмшигчдийн хурал танилцуулна.

8.6. Олон Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын болон Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу Сангийн сайдын баталсан санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй үзүүлэлтүүд, маягт, аргачлал мөрдөнө.

8.7. Компани Монгол улсын аль нэгэн болон хэд хэдэн банкинд төгрөгийн болон гадаад валютын данс нээх эрхтэй бөгөөд шинээр данс нээлгэсэн, хаалгасан тухай бүр Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж байна. Компани гадаадын

банкинд гадаад валютын данс нээх бол энэ тухайгаа Монгол банк болон Татварын албанд албан ёсоор мэдэгдэнэ.

8.8. Ногдол ашгийн хуваарилалт:

8.8.1. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг ТУЗ гаргана. ТУЗ-ийн тогтоолд хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах "бүртгэлийн өдөр" болон ногдол ашиг төлж эхлэх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.

8.8.2. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон компанийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

8.8.3. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна:

8.8.3.1. ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

8.8.3.2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

8.8.3.3. Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

8.9. Компани жилийн санхүүгийн тайлангийн цээр ашгийн 20-оос доошгүй хувиар ногдол ашиг хуваарилж болно. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ, ногдол ашиг хуваарилах хугацаа зэргийг Төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

8.10. Ногдол ашиг, хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд өөрийн ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор хөрөнгө оруулагчид өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

8.11. Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Уг санг байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг гүйцэтгэх захирал боловсруулж ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөнө.

8.12. Ногдол ашиг хуваарилцах тухай ТУЗ-ийн шийдвэр гаргасан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашиг аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтлөнө. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигч бүрийн арилжааны дансанд шилжүүлэх бодлого баримтална.

8.13. Компани ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж Санхүүгийн Зохицуулах Хороо, Хөрөнгийн Биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа

эзэмшигчдийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

**Ес. Компанийн санхүү, эдийн засгийн  
үйл ажиллагаанд тавих аудиторын хяналт**

- 9.1. Компани санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудитын байгууллагыг томилон ажиллуулна.
- 9.2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо аудиторыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална.
- 9.3. Аудитын хороо аудитортой байгуулах гэрээнд компанийн болон аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана.
- 9.4. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.
- 9.5. Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ.
- 9.6. Ээлжит бус шалгалтыг төлөөлөн удирдах зөвлөл, түүний аудитийн хороо, эсхүл энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчийн шаардсанаар хэдийд ч хийж болно.
- 9.7. Аудитын байгууллагын ээлжит шалгалтын хөлсийг компани хариуцан төлнө.
- 9.8. Шалгалтын явцад компаний эрх бүхий албан тушаалтан компанид хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд хариуцан төлнө.
- 9.9. Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.
- 9.10. Компанийн тухай хуулийн 94.10-г заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтны буруугаас аудитын байгууллагын буюу аудиторын ажил зогссон хоногт оногдох ажлын хөлсийг буруутай этгээдээр төлүүлэх шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.
- 9.11. Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлбар өгөх үүрэгтэй оролцох эрхтэй.
- 9.12. Дор дурдсан этгээдийг компанийн аудиторoor сонгон ажиллуулахыг хориглоно:
  - 9.12.1. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;
  - 9.12.2. компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг бол;

- 9.12.3. аудитын үйлчилгээ үзүүлэхээс бусад асуудлаар компанитай хэлцэл хийсэн этгээд бол.
- 9.13. Компанийн тухай хуулийн 94.13-т заасныг зөрчиж аудиторыг сонгосон бол түүний аудитын дүгнэлтийг хүчингүйд тооцно.
- 9.14. Аудитын байгууллагын гаргасан дүгнэлтийн шинж чанараас хамааруулан олгох хөлсний хэмжээ тогтоохыг хориглоно.
- 9.15. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалт /баримтын шалгалт/-ын дүнг үндэслэн компанийн аудитор нь дараах мэдээллийг агуулсан дүгнэлт гаргана:
  - 9.15.1. компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт үнэн зөв эсэх;
  - 9.15.2. нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт зохих журмын дагуу хийгдсэн эсэх, зөрчил илэрвэл уг зөрчлийг тохиолдол тус бүрээр тодорхойлох;
  - 9.15.3. шалгалтын хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн жгасаалт, уг хэлцлийг журмын дагуу хийсэн эсэх тухай тодорхойлолт;
  - 9.15.4. хувьцаат компанийн хувьд үнэт цасны зах зээлийн тухай хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооны болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон бусад мэдээлэл;
  - 9.15.5. компанийн дүрэм болон аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээгээр тодорхойлсон бусад мэдээлэл.
- 9.16. Аудитын байгууллага нь өөрийн хийсэн аудитын дүгнэлтээс үүссэн хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна.

#### **Арав. Нэгдмэл сонирхолтой этгээд**

- 10.1. Дор дурдсан этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтан, компанийн хувьцааны 5 дээш хувийг эзэмшигч этгээдтэй нэгдмэл сонирхолтой этгээд гэж үзнэ. Үүнд:
  - 10.1.1. тэдгээрийн гэр бүлийн гишүүд, эхнэр, нөхөр;
  - 10.1.2. тэдгээрийн эцэг, эх, хүүхдүүд, ач зээ болон бусад төрөл, садан;
  - 10.1.3. тэдгээр нь өөрсдийн ажиллаж буй болон хувьцаа эзэмшидэг компанитай хийгдэж буй хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар хүртэж буй тохиолдолд уг гэрээг хийгч этгээд;
  - 10.1.4. нэг гэр бүлийн гишүүд, эхнэр нөхөр, эцэг эх, хүүхдүүд, ач зээ нар ах дүүс, бусад төрөл садан;
  - 10.1.5. нэг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид;
  - 10.1.6. өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь хяналтын багцыг нь эзэмшдэг болон эрх бүхий албан тушаалд ажилладаг компани;
  - 10.1.7. уг этгээд ажил олгогч бол, түүний ажилтнууд.

#### **Арван нэг. Компанийг татан буулгах**

- 11.1. Компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр Иргэний хууль, Компанийн тухай хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр татан буулгана.

- 11.2. Компанийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгана:
- 11.2.1. Дор дурдсан нөхцөл байдал бий болсон, эсхүл удаан хугацаагаар үргэлжилж байгааг харгалзан хувьцаа эзэмшигч аль нэгэн талын гаргасан саналыг авч хэлэлцээд санал нэгтэй шийдвэр гаргасан;
- Компанийн үйл ажиллагаа алдагдалтай, цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;
  - Компанийг татан буулгахыг хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхи зөвөөрсөн;
  - Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан үндэслэл;
  - Хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхи нь компанийг хуваах өөр компанид нэгдэх шийдвэр гарсан.
- 11.2.2. Монгол Улсын шүүх компанийг дор дурдсан үндэслэлээр татан буулгана:
- Дампуурсан;
  - Нэг ч гишүүн үлдээгүй;
  - Хуульд заасан бусад үндэслэл.
- 11.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буугдаж байгаа компанийн ТУЗ нь компанийг татан буулгах комисс томилж, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараагаар компанид үлдэж байгаа эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцогчдын саналын дийлэнх олонхоор шийдвэрлүүлнэ.
- 11.4. Татан буулгах комисс томилсноор тус компанийн гүйцэтгэх захирал буюу гүйцэтгэх удирдлын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжих бөгөөд уг комисс нь компанийн нэрийн өмнөөс шүүх хуралд төлөөлөн оролцоно. Татан буулгах комисс дараах үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:
- 11.4.1. компанийг татан буулгах шийдвэрийг нийтэд мэдээлэх;
- 11.4.2. дуусгалтын баланс, тайлан гаргаж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх;
- 11.4.3. өр төлбөрийг хуульд заасан дараалал, журмын дагуу барагдуулах;
- 11.4.4. үлдсэн эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилах;
- 11.4.5. татан буулгах ажиллагаа дууссаныг татварын албанд мэдэгдэх.
- 11.5. Татан буулгах комисс үүргээ биелүүлэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн компанид, эсхүл зээлдүүлэгчид ямар нэг хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасны дагуу хариуцна.
- 11.6. Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах хугацаа, журмыг нийтэд болон зээлдүүлэгчдэд мэдээлнэ. Нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах хугацаа нийтэд мэдээлснээс хойш 3 сар байна.
- 11.7. Татан буулгах шийдвэр гарах үед компани ямар нэг өргүй байвал компанийг татан буулгах тухай нийтэд мэдээлэхгүй байж болно.

- 11.8. Нэхэмжлэл гаргах хугацаа дууссан өдрөөр тасалбар болгон компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, зээлдүүлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын дүнг тусгасан татан буулгах түр балансыг гаргах бөгөөд уг балансыг ТУЗ батална.
- 11.9. Татан буулгах комисс нэхэмжлэлийг хэрхэн барагдуулах тухайгаа нэхэмжлэгчдэд бичгээр мэдэгдэнэ.
- 11.10. Компанийн мөнгөн хөрөнгө нь нэхэмжлэлийг барагдуулахад хангалтгүй бол татан буулгах комисс компанийн бусад эд хөрөнгийг худалдаж болно.
- 11.11. Зээлдүүлэгчийн өр төлбөрийг барагдуусны дараа үндсэн эд хөрөнгө, эсхүл тэдгээрийг худалдаж борлуулсан орлогыг хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлж хуваарилна.
- 11.12. Компанийн бүх эд хөрөнгийг хуваарилсны дараа татан буулгах комисс компанийг татан буулгах замаар үйл ажиллагаа дуусгавар болсоныг бүртгэх байгууллагад мэдэгдэж, татан буулгах балансын нэг хувийг хүргүүлнэ.
- 11.13. Компанийг бие даасан өөр компанитай нэгтгэж шинээр компани байгуулах, эсхүл өөр компанийг өөртөө нэгтгэсэн буюу өөрөө өөр компанид нийлж томрох, түүнчлэн компанийг бие даасан хэд хэдэн компани болгон хуваах буюу компаниас өөр компани шинээр тусгаарлах аргаар өөрчлөн байгуулж болно.
- 11.14. Компани нь өөртөө өөр компани нэгтгэх, өөрөөсөө шинээр компани тусгаарлан гаргасан тохиолдолд тус компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхээ хадгалж үлдэнэ.

**Арван хоёр. Нэмэлт, өөрчлөлт**

- 12.1. Компанийн ТУЗ нь энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.

**Арван гурав. Дүрэм хүчин төгөлдөр болох**

- 13.1. Энэ дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар батална.
- 13.2. Энэ дүрэм нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэснээр хүчин төгөлдөр болно.

\*\*\*



## “МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04-р сарын 26-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

### Төлөөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7-д заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.9-д заалт, 2021 оны 04 сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

#### 1. “Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр

1. Лхагважавын Ариунболд
2. Галбадрахын Ганзориг
3. Бадарчийн Шаравсамбуу
4. Пүрэвбанзрагчийн Сайнбилэг
5. Ариунболдын Энхгэрэл
6. Хан Гю Бунг нарыг тус тус сонгосугай.

#### 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр

1. Шаравсамбуугийн Энхтөр
2. Чансаагийн Зоригтбаатар
3. Пүрэвсүхийн Нямдорж нарыг тус тус сонгосугай.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, Компанийн дүрэм болон бусад хууль тогтоомжийг баримтлан компанийн эрх ашгийг дээдлэн ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



А.ЭНХГЭРЭЛ



## “МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04-р сарын 26-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

### Төлөөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.13-д заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.1.5.15-д заалт, 2021 оны 04 сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг сар бүр тооцон, хууль тогтоомжийн дагуу олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Б.Болортуяа/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



А.ЭНХГЭРЭЛ

“Монгол Базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
 ээлжит хурлын 4 тоот тогтоолын хавсралт



“Монгол Базальт” ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ

| ТУЗ-ийн гишүүдийн цалин             |                                                                                       | Хэмжээ /төгрөг/ |
|-------------------------------------|---------------------------------------------------------------------------------------|-----------------|
| Тогтмол цалин                       | Үндсэн                                                                                | 1,000,000 ₮     |
|                                     | ТУЗ-ийн даргын нэмэгдэл                                                               | 200,000 ₮       |
|                                     | Хорооны даргын нэмэгдэл                                                               | 100,000 ₮       |
| Оролцоонд үндэслэсэн нэмэгдэл цалин | Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд биечлэн оролцсон тоогоор | 100,000 ₮       |

| Хурлууд:                                         | Хурлын давтамж, тоо |
|--------------------------------------------------|---------------------|
| Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал                | Жилдээ 1 удаа       |
| Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал                 | Жилдээ 4 удаа       |
| ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны хурал           | Жилдээ 4 удаа       |
| ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны хурал     | Жилдээ 2 удаа       |
| ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны хурал | Жилдээ 1 удаа       |